



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/233

Ховд

Аймгийн Онцгой комисс, гамшгаас хамгаалах албад,
мэргэжлийн ангийг шинэчлэн байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, 32.1.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 152 дугаар тогтоолын 1.3 дахь заалт, Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 75 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг аймгийн нутаг дэвсгэрт удирдан зохион байгуулах үүрэг бүхий Онцгой комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар, ажлын хэсгийг гуравдугаар, Гамшгаас хамгаалах албадын томилгоог дөрөвдүгээр, Төрийн захиргааны болон төрийн өмчит, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагыг түшиглэн байгуулах тусгай зориулалтын Мэргэжлийн ангийн жагсаалтыг тавдугаар хавсралтаар тус тус шинэчилэн байгуулсугай.

2. “Мэргэжлийн ангийн дүрэм”, “Гамшгаас хамгаалах орон нутгийн албаны ажиллах нийтлэг журам”-д зааснаар гамшгаас хамгаалах алба, тэдгээрийн штаб, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний томилгоог сумын Засаг даргын Захирамж, байгууллагын дарга, захирлын тушаалаар 2019 оны 05 дугаар сарын 10 – ны дотор томилгоожуулж, шинэчлэн зохион байгуулахыг сумдын Засаг дарга, аж ахуйн нэгж байгууллагын дарга /захирал/ нарт үүрэг болгосугай.

3. Онцгой комиссын бүрэлдэхүүн шинэчлэгдсэнтэй холбогдуулан Онцгой комиссын гишүүдийн нэр, гэрийн хаяг, утасны жагсаалтад тодотгол хийж аймгийн гамшгаас хамгаалах, бэлэн байдлын төлөвлөгөөнд тусгаж, зарлан мэдээллийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Онцгой комиссын орлогч дарга / Баруун бүсийн

Zax A/233 Ch
02 01147

төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа Б.Алтанбадралт/-д үүрэг болгосугай.

3. Аймгийн нутаг дэвсгэрт гамшгаас хамгаалах ажлыг удирдан зохион байгуулах Онцгой комисс, гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн ангийг шуурхай удирдлагаар хангаж ажиллахыг Онцгой комиссын орлогч дарга / Баруун бүсийн төв-ховд аймгийн Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа Б.Алтанбадралт/-д даалгасугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/235 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Ховд аймгийн Засаг даргын
2019 оны 04 дүгээр сарын 15 – ны өдрийн
А/233 дугаар захирамжийн нэгдүгээр
хавсралт

ХОВД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Онцгой комиссын дарга:

- Аймгийн Засаг дарга

Онцгой комиссын орлогч дарга:

- Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын дарга

Гишүүд:

- Аймгийн дэд бүтэц, эдийн засгийн бодлого хариуцсан Засаг даргын орлогч

- Аймгийн нийгмийн бодлого хариуцсан Засаг даргын орлогч

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

- Цагдаагийн газрын дарга

- Тагнуулын газрын дарга

- Цэргийн штабын дарга

- Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн захирагч

- Эрүүл мэндийн газрын дарга

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал

- Мэргэжлийн хяналтын газрын дарга

- Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

- Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга

- Ус цаг уур орчны шинжилгээний газрын дарга

- Мэдээлэл, холбооны сүлжээ Төрийн өмчит ХХ Компаний Ховд аймаг дахь газрын дарга

- Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга

- Мал эмнэлгийн газрын дарга

- Боловсрол, соёл урлагийн газрын дарга

- Зооноз өвчин судлалын төвийн дарга

- Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга

- Цахилгаан түгээх сүлжээ ХХК-ны дарга

- Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын дарга

- Авто тээврийн төвийн дарга

- Аймгийн Улаан загалмайн хорооны дарга

- Ховд олон улсын Нисэх буудлын дарга

- Нутаг дэвсгэрт нь онцгой байдал үүссэн сумын Засаг дарга

Нарийн бичгийн дарга

- Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын орлогч,
урьдчилан сэрийлэх хяналтын тасгийн дарга

-оОо-

Ховд аймгийн Засаг даргын
2019 оны 04 дүгээр сарын 15 – ны өдрийн
А/233 дугаар захирамжийн хоёрдугаар
хавсралт

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Аймгийн онцгой комисс Гамшгаас хамгаалах тухай хуулинд заасан аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчныг аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэх, тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэр, орон нутгийн төрийн болон аж ахуй нэгж, албан тушаалтны үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, шуурхай зохион байгуулах, хяналт тавихдаа энэ журмыг дагаж мөрдөнө.

1.2. Аймгийн онцгой комисс /цаашид комисс гэх/ нь Гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ журмыг удирдлага болгон үйл ажиллагаагаа явуулна.

1.3. Онцгой комиссын бүрэлдэхүүн, ажиллах журамыг аймгийн Засаг дарга батална.

1.4. Онцгой комиссыг аймгийн Засаг дарга тэргүүлэх бөгөөд орлогч дарга нь Онцгой байдлын газрын дарга байна.

1.5. Онцгой комиссын хурал нийт гишүүдийн 60-аас доошгүй хувийн ирцтэй бол хүчин төгөлдөр болох бөгөөд хэлэлцсэн асуудлыг хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэж, тэмдэглэл гаргана.

1.6. Онцгой комиссын дарга нь холбогдох хууль тогтоомжоор олгогдсон үүрэг, зорилтоо хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг эрх хэмжээнийхээ хүрээнд албан даалгавар, тушаал, албан бичиг гаргана.

1.7. Онцгой комиссын гишүүд нь тогтоосон загварын дагуу үйлдсэн үнэмлэхтэй байна.

1.8. Онцгой комиссоос гаргасан шийдвэрийг орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, албан тушаалтан, иргэд өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан дагаж мөрдөнө.

1.9. Онцгой комиссын өдөр тутмын үйл ажиллагааг Онцгой комиссын нарийн бичгийн дарга эрхэлнэ.

Хоёр. Онцгой комиссын эрх үүрэг

2.1. Онцгой комисс дараах үүрэгтэй байна.

2.1.1 Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний бэлтгэлийг хангуулах ажлыг орон нутгийн төрийн захиргааны болон аж ахуй нэгж, төрийн бус, олон нийтийн байгууллагаар гүйцэтгүүлэх, Монгол Улсын Шадар сайд, Улсын Онцгой комиссоос энэ чиглэлээр тусгайлан өгсөн үүргийг хэрэгжүүлэх.

2.1.2 Гамшгийн голомтод аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг удирдан зохион байгуулах, эдгээр арга хэмжээнд оролцож байгаа байгууллага, аж ахуй нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах

2.1.3 Гамшгийн цагийн байдалд мэргэжлийн байгууллагаас өгсөн үнэлэлт, дүгнэлт, авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг хэлэлцэж шийдвэр гаргах

2.1.4 Гамшгийн голомтод Засгийн газар, олон улсын болон хүмүүнлэгийн байгууллагаас олгосон бараа, материал, тусламжийг хүргэх болон тээвэрлэх явцад хяналт тавих

2.1.5 Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, нэрвэгдэгсэдэд шуурхай тусламж үзүүлэх, нүүлгэн шилжүүлэх ажилд шаардагдах хүн хүч, техник хэрэгслийг зохих журмын дагуу дайчлан гаргах асуудлыг орон нутгийн төрийн захиргааны болон бусад байгууллага, албан тушаалтантай хамтран шийдвэрлэж зохицуулах, шаардлагатай нэмэгдэл хүч, техник хэрэгсэлийг дайчлан гаргах

2.1.6 Гамшгийн аюулаас хүн ам, мал, амьтан, хүрээлэн байгаа орчныг аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхэд тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хүч хүрэлцэхгүй болсон үед улсын онцгой комисст албан ёсны хүсэлт тавих

2.1.7 Комиссоос олон нийтэд хүргэх анхааруулга, санамж болон авч хэрэгжүүлж буй арга хэмжээнийхээ талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай мэдээлж байх

2.1.8 Гамшиг тохиолдсон үед хохирлыг үнэлэх ажлын хэсгийг мэргэжлийн байгууллагуудаас томилон ажиллуулах, дүгнэлт гаргуулах

2.2. Онцгой комисс дараахь эрхтэй байна.

2.2.1 Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлаар орон нутгийн төрийн захиргааны болон аж ахуй нэгж, байгууллагын дарга нарт үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулах, гүйцэтгэлд хяналт тавих

2.2.2 Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээнд орон нутгийн төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллага, албан тушаалтан, гадаадын хөрөнгө оруулалттай

болон дотоодын аж ахуй нэгж, иргэдийг хууль тогтоомжийн дагуу өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан татан оролцуулах

2.2.3 Холбогдох байгууллага, албан тушаалтнаас шаардлагатай тайлан, мэдээ мэдээлэл, судалгаа гаргуулан авах, илтгэл, мэдээллийг хурлаараа хэлэлцэж, шийдвэр гарган биелүүлэхийг шаардах, хяналт тавих

2.2.4 Гамшгийн голомтод хэрэгжүүлж байгаа арга хэмжээг шалгаж дүгнэлт гаргах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах

2.2.5 Комиссоос олон нийтэд хүргэх анхааруулга, санамж болон авч хэрэгжүүлж буй арга хэмжээнийхээ талаар мэдээлэл хийхдээ хэвлэл, мэдээллийн хэрэгслийг холбогдох журмын дагуу ашиглах.

2.2.6. Комиссоос гарсан шийдвэр, хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар зөвхөн Онцгой комиссын дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга мэдээллийг олон нийтэд хүргэнэ.

2.2.7. Онцгой комиссын гишүүд нэг төрлийн хувцас, үнэмлэхтэй байна.

2.2.8. Аймгийн Онцгой комисс нь хурлын тэмдэглэл, Онцгой комиссын шийдвэр, албан даалгавар, тушаал, албан бичгийн хэвлэмэл хуудастай байна.

Гурав. Онцгой комиссын гишүүний эрх, үүрэг

3.1. Онцгой комиссын гишүүн дараахь үүрэгтэй байна:

3.1.1. Хуралд биечлэн оролцож бий болсон нөхцөл байдалтай холбогдуулан өөрийн эрхлэх ажлын хүрээнд шийдвэрлэх асуудлаар санал оруулах, гамшгийн голомт буюу хорио цээрийн дэглэм тогтоосон газарт зохих журмын дагуу нэвтэрч үйл ажиллагааг нь шалгаж, заавар зөвлөгөө өгөх

3.1.2. Гамшгаас хамгаалах хууль тогтоомж түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан дүрэм, журам, аймгийн онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг хянаж шалгах

3.1.3. Орон нутагт ажиллахдаа тухайн сумын Онцгой комиссын ажлыг шалган танилцаж, заавар зөвлөгөө өгөх, тавьсан санал хүсэлтийг өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх,

3.1.4. Комиссын чиглэлээр гүйцэтгэсэн ажлынхаа талаар комиссын даргад албан ёсоор танилцуулах

3.1.5. Комиссын гишүүн нь ээлжийн амралт эдлэх, албан ажлаар Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт ажиллах үедээ түр орлон гүйцэтгэгчийн нэр, албан тушаалын талаарх мэдээллийг онцгой комиссын нарийн бичгийн даргад мэдэгдэх

3.1.6. Аймаг орон нутагт тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэлийн хор уршгийг арилгах, хойшлуулшгүй ажлын шаардлагаар өдөр, шөнийн аль ч цагт дуудахад дурдсан хугацаанд, заасан газарт хүрэлцэн ирэх

3.2. Онцгой комиссын гишүүн дараахь эрхтэй байна:

3.2.1. Аймаг болон сумдын гамшгийн нөөц бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалт, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, зайлшгүй сэргээн босгох арга хэмжээнд ашиглах техник хэрэгслийн бэлэн байдлыг шалгах, шаардлагатай бол комиссын хуралд асуудал танилцуулж авах арга хэмжээний талаар санал оруулж шийдвэрлүүлэх

Дөрөв. Сумын онцгой комисс үүрэг

4.1. Сумын Онцгой комисс дараахь үүрэгтэй

4.1.1. Сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргын Захирамжийг үндэслэн сумын онцгой комисс / цаашид комисс гэх/-ын байгуулна.

4.1.2. Комиссын дарга нь сумын Засаг дарга, орлогч нь Тамгын газрын дарга байна.

4.1.3. Комисс нь нутаг дэвсгэртээ гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэх, аймгийн онцгой комиссоос үүрэг даалгаврын биелэлтийг хангах үүрэгтэй.

4.1.4. Сумын Онцгой комисс нь үүссэн нөхцөл байдал, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулашгүй сэргээн босгох талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг хэлэлцэн, шийдвэрийг хүсэлтийн хамт аймгийн онцгой комисст яаралтай ирүүлнэ.

4.1.5. Сумын нутаг дэвсгэрт тохиолдсон гамшгийн улмаас учирсан хохирлыг эхний ээлжинд гамшгаас хамгаалах нөөц сангийн хөрөнгөөс зарцуулах, хэрэв дээрхи хөрөнгөөс давсан тохиолдолд аймгийн онцгой комисст сумын засаг даргын гамшгаас хамгаалах нөөц хөрөнгийн зарцуулалт, зарцуулалтын тайланг бичгээр ирүүлсэний дараа аймгийн Засаг даргын нөөц сангаас нэмэлт санхүүжилт гаргуулах хүсэлтээ ирүүлэх.

4.1.6. Комисс нь энэхүү журамд заасан үүргийг биелүүлж, эрхийг эдэлнэ.

Тав. Комиссын зардал

5.1. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь заалт аймгийн болон сумын тухайн жилийн төсвийн 1,0 хувийг орон нутгийн гамшгийн эрсдлийг бууруулах санд тусгаж, гамшгаас хамгаалах арга хэмжээнд зарцуулна гэсэн заалтийн дагуу гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг

арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдсон хөрөнгө, зардлыг захиран зарцуулна.

5.2. Онцгой комиссын гишүүдийг сургаж дадлагажуулах, бэлэн байдлыг хангуулах, өдөр тутмын үйл ажиллагааг хангахад зарцуулагдах зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулна.

5.3. Комисс нь орон нутгийн хэмжээнд гамшигтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр зарцуулсан, бие даан шийдвэрлэх боломжгүй зардлыг Улсын онцгой комисст хүсэлт гарган шийдвэрлүүлнэ.

5.4 Гамшигтай тэмцэх, урьдчилан сэргийлэх сургууль, дадлага, аврах ажиллагаанд үүргээ хангалттай биелүүлсэн байдал, комиссын хуралд оролцсон оролцоог харгалзан онцгой комиссын гишүүдэд хагас жилд 1 удаа урамшуулал олгож болно.

Зургаа. Бусад зүйл

6.1. Аймгийн Онцгой комисс нь гамшгийн үед зохион байгуулсан арга хэмжээ, үр дүн, тайлан мэдээг жил бүрийн 12 дугаар сард Улсын онцгой комисст явуулна.

6.2. Комисс нь дүрмэндээ орон нутгийн онцлогийг тусгасан заалт нэмж оруулж болно

6.3. Өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэнд захиргааны шийтгэл ногдуулах саналаа эрх бүхий холбогдох байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлнэ.

Ховд аймгийн Засаг даргын
2019 оны 04 дүгээр сарын 15- ны өдрийн
А/233 дугаар захирамжийн гуравдугаар
хавсралт

ОНЦГОЙ КОМИССЫН АЖЛЫН ХЭСГҮҮД

1. Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлын хэсэг

Дарга :

- Аймгийн Онцгой комиссын орлогч дарга

Орлогч:

- Аймгийн дэд бүтэц, эдийн засгийн бодлого хариуцсан Засаг даргын орлогч

Гишүүдэд:

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
- Цагдаагийн газрын дарга
- Тагнуулын газрын дарга
- Цэргийн штабын дарга
- Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн захирагч
- Эрүүл мэндийн газрын дарга
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал
- Мэргэжлийн хяналтын газрын дарга
- Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга
- Мэдээлэл, холбооны сүлжээ Төрийн өмчит ХХ Компаний Ховд аймаг дахь газрын дарга
- Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга
- Боловсрол, соёл урлагийн газрын дарга
- Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга
- Цахилгаан түгээх сүлжээ ХХК-ны дарга
- Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын дарга
- Авто тээврийн төвийн дарга
- Аймгийн Улаан загалмайн хорооны дарга
- Нутаг дэвсгэрт нь онцгой байдал үүссэн сумын Засаг дарга
- Одон орон геофизик хүрээлэнгийн ховд салбарын дарга

2. Ой хээрийн болон объектын гал түймэр, цаг агаарын аюулт үзэгдэлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлын хэсэг

Дарга :

- Аймгийн Онцгой комиссын орлогч дарга

Орлогч:

- Дэд бүтэц, эдийн засгийн бодлого хариуцсан Засаг даргын орлогч

Гишүүдэд:

- Засаг даргын Тамгын газрын дарга

- Цагдаагийн газрын дарга
- Цэргийн штабын дарга
- Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн захирагч
- Эрүүл мэндийн газрын дарга
- Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал
- Мэргэжлийн хяналтын газрын дарга
- Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга
- Ус цаг уур орчны шинжилгээний газрын дарга
- Мэдээлэл, холбооны сүлжээ Төрийн өмчит ХХК-ний Ховд аймаг дахь газрын дарга
- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал
- Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга
- Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын дарга
- Авто тээврийн төвийн дарга
- Аймгийн Улаан загалмайн хорооны дарга
- Нутаг дэвсгэрт нь онцгой байдал үүссэн сумын Засаг дарга

3.Хүн, мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлын хэсэг

Дарга :

- Аймгийн Онцгой комиссын орлогч дарга

Орлогч:

- Мал эмнэлгийн газрын дарга
- Эрүүл мэндийн газрын дарга

Гишүүдэд:

- Дэд бүтэц, эдийн засгийн бодлого хариуцсан Засаг даргын орлогч
- Нийгмийн бодлого хариуцсан Засаг даргын орлогч
- Засаг даргын Тамгын газрын дарга
- Цагдаагийн газрын дарга
- Тагнуулын газрын дарга
- Мэргэжлийн хяналтын газрын дарга
- Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал
- Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
- Зооноз өвчин судлалын төвийн дарга
- Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга

- Авто тээврийн төвийн дарга
- Нутаг дэвсгэрт нь онцгой байдал үүссэн сумын Засаг дарга

4.Барилга, техникийн холбогдолтой осол, цацраг химийн хорт бодис алдагдахаас сэргийлэх, тэмцэх ажлын хэсэг

Дарга :

- Аймгийн Онцгой комиссын орлогч дарга

Орлогч:

- Мэргэжлийн хяналтын газрын дарга
- Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга

Гишүүдэд:

- Дэд бүтэц, эдийн засгийн бодлого хариуцсан Засаг даргын орлогч
- Засаг даргын Тамгын газрын дарга
- Цагдаагийн газрын дарга
- Тагнуулын газрын дарга
- Цэргийн штабын дарга
- Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн захирагч
- Эрүүл мэндийн газрын дарга
- Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал
- Ус цаг уур орчны шинжилгээний газрын дарга
- Мэдээлэл, холбооны сүлжээ Төрийн өмчит ХХ Компаний Ховд аймаг дахь газрын дарга
- Цахилгаан түгээх сүлжээ ХХК-ны дарга
- Авто тээврийн төвийн дарга
- Нутаг дэвсгэрт нь онцгой байдал үүссэн сумын Засаг дарга

5.Террорист халдлагаас урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлын хэсэг

Дарга :

- Аймгийн Онцгой комиссын орлогч дарга

Орлогч:

- Цагдаагийн газрын дарга
- Тагнуулын газрын дарга

Гишүүдэд:

- Дэд бүтэц, эдийн засгийн бодлого хариуцсан Засаг даргын орлогч
- Цэргийн штабын дарга
- Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн захирагч
- Эрүүл мэндийн газрын дарга

- Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал
- Мэргэжлийн хяналтын газрын дарга
- Мэдээлэл, холбооны сүлжээ Төрийн өмчит ХХ Компаний Ховд аймаг дахь газрын дарга
- Цахилгаан түгээх сүлжээ ХХК-ны дарга
- Төрийн сангийн хэлтсийн дарга
- Авто тээврийн төвийн дарга
- Нутаг дэвсгэрт нь онцгой байдал үүссэн сумын Засаг дарга

6. Өвөлжилт хүндэрсэн болон зам гүүр, даваа хаагдахаас урьдчилан сэргийлэх ажлын хэсэг

Дарга :

- Аймгийн Онцгой комиссын орлогч дарга

Орлогч:

- Дэд бүтэц, эдийн засгийн бодлого хариуцсан Засаг даргын орлогч

Гишүүдэд

- Засаг даргын Тамгын газрын дарга
- Цагдаагийн газрын дарга
- Цэргийн штабын дарга
- Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн захирагч
- Эрүүл мэндийн газрын дарга
- Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал
- Мэргэжлийн хяналтын газрын дарга
- Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
- Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга
- Ус цаг уур орчны шинжилгээний газрын дарга
- Цахилгаан түгээх сүлжээ ХХК-ны дарга
- Авто тээврийн төвийн дарга
- Аймгийн Улаан загалмайн хорооны дарга
- Ховд АЗЗА ХХК-ны захирал
- Нутаг дэвсгэрт нь онцгой байдал үүссэн сумын Засаг дарга

Ховд аймгийн Засаг даргын
2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн
А/233 дугаар захирамжийн дөрөвдүгээр
хавсралт

АЙМГИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ
АЛБАДЫН ТОМИЛГОО

1. Эрүүл мэндийн газрын түшиглүүлэн - Эрүүл мэндийн албыг /Ц.Мягмарсүрэн/
2. Хүнс, хөдөө аж ахуйн газрыг түшиглүүлэн - Хүнс, хөдөө аж ахуйн албыг /Г.Гончигсүрэн /
3. Тээвэр, авто замын газрыг түшиглүүлэн - Зам, тээврийн албыг /Н.Ирхзаяа/
4. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрыг түшиглүүлэн - Барилга хот байгуулалтын албыг /Б.Баярсүх /
5. Мэргэжлийн хяналтын газрыг түшиглүүлэн - Мэргэжлийн хяналтын албыг /П.Эрдэнэчулуун /
6. Цагдаагийн газрыг түшиглүүлэн - Хэв журам сахиулах албыг /Б.Батзаяа /
7. Хөдөлмөр халамж үйлчилгээний газрыг түшиглүүлэн - Хүн ам, нийгмийн хамгаалалын албыг /Л.Билэгдэмбэрэл /
8. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийг түшиглүүлэн - Дэд бүтэц, уул уурхайн албыг /С.Гантөмөр /
9. Ус цаг уур орчны шинжилгээний газрыг түшиглүүлэн - Байгалийн болон цацраг химийн аюулыг үнэлж мэдээлэх албыг /А.Энхзаяа /
10. Ховд Цахилгаан түгээх сүлжээ ХХКомпанийг түшиглүүлэн - Эрчим хүчээр хангах албыг /Ш.Арстай /
11. Мэдээлэл, холбооны сүлжээ Төрийн өмчит ХХКомпаний Ховд аймаг дахь газрыг түшиглүүлэн - Мэдээлэл, харилцаа холбооны албыг /С.Лхагвасүрэн/
12. Мал эмнэлгийн газрыг түшиглэн – Мал эмнэлгийн алба /Д.Батцэнгэл/
13. Орон нутгийн хэвлэл мэдээлэлийн Ховд телевизийг түшиглүүлэн - Сурталчилгааны албыг /Ж.Самбалхүндэв /

Ховд аймгийн Засаг даргын
2019 оны 04 дүгээр сарын 15- ны өдрийн
А/233 дугаар захирамжийн тавдугаар
хавсралт

АЙМГИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ АЛБА,
МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫГ ТҮШИГЛЭН БАЙГУУЛАХ
ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН МЭРГЭЖЛИЙН АНГИЙН
ЖАГСААЛТ

№	Түшиглэж байгуулах байгууллага, аж ахуйн нэгжийн нэр	Мэргэжлийн ангийн ангилал	Хүний тоо	Хариуцах албан тушаалтан
1	Бүсийн оношлогоо эмчилгээний төв	Яаралтай тусламжийн бүлэг	20	П.Улаанхүү
2		Хээрийн эмнэлэг	20	
3		Эм, эмнэлгийн хэрэгсэлээр хангах бүлэг	8	
4		Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх бүлэг	10	
5		Цус сэлбэх хөдөлгөөнт бүлэг	5	
6	Зооноз өвчин судлалын төв	Зоонозын өвчинтэй тэмцэх бүлэг	10	Б.Баяржаргал
7	Хөдөлмөр халамж, үйлчилгээний газар	Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах бүлэг	10	Л.Билэгдэмбэрэл
8	Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар	Хүүхэд хамгаалал, боловсролын бүлэг	10	Б.Номинчимэг
9	Аймгийн Улаан загалмайн хороо	Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн бүлэг	5	Б.Одонпүрэв
10		Олон улсын хүмүүнлэгийн тусламжийн бүлэг	5	
11	Санхүү, Төрийн сангийн хэлтэс	Санхүү, нөөцийн бүлэг	5	Ч.Багдал
12	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийтлэг үйлчилгээний хэлтэс	Хүнсний хангалтын бүлэг	6	Д.Эрдэнэцэцэг
13		Орон байр, хувцас хангалтын бүлэг	6	
14	Авто тээврийн төв	Тээврийн бүлэг	6	Н.Ирэхзаяа
15	Нефть хангамжийн Ховд салбар	Шатахуун, хийн түлш хангалтын бүлэг	8	Н.ОюунЭрдэнэ
16	Боловсрол соёл урлагын газар	Нүүлгэн шилжүүлэлт, түр байрны бүлэг	20	М.Пүрэвхүү
17		Хорогдох байрны бүлэг	12	
18	Улсын бүртгэлийн хэлтэс	Иргэний бүртгэл, мэдээллийн бүлэг	8	С.Хоролсүрэн

19	Статистикийн хэлтэс	Статистик мэдээллийн бүлэг	8	Д.Даваасамбуу
20	Онцгой байдлын газрын гал түймэр унтраах аврах 38, 48, 70 дугаар анги	Гал унтраах мэргэжлийн анги	40	Б.Ганзориг Ц.Чунагсүрэн М.Энхдалай
21	"Ховд Дулааны станц" ТӨХК	Дулааны шугам сүлжээний засварын бүлэг	15	Д.Энхсайхан
22	Нийтийн аж ахуйн Шим ус ОНӨХКомпани	Цэвэр, бохир усны засварын бүлэг	15	Б.Баатарзориг
23		Уст цэг хамгаалах бүлэг	6	
24	Ховд цахилгаан түгээх сүлжээ ХХКомпани	Цахилгааны шугам сүлжээний засварын бүлэг	15	Ш.Арстай
25	Зам засвар арчлалтын Ховд – АЗЗА ХХКомпани	Зам, гүүрийн засварын бүлэг	15	Б.Батсүх
26	Цагдаагийн газар	Хэв журам сахиулах бүлэг	35	Б.Батзаяа
27	Зэвсэгт хүчний 123 дугаар анги	Тусгай бүлэг	21	М.Болдбаатар
28		Инженер, тэсэлгээний бүлэг	10	
29	Ус цаг уур орчны шинжилгээний газар	Цацраг, химийн хяналтын бүлэг	8	А.Энхзаяа
30	Хүнс хөдөө аж ахуйн газар	Ургамал, газар тариалан хамгаалах бүлэг	8	Г.Гончигсүрэн
31	Мал эмнэлгийн газар	Мал эмнэлэгийн нарийн мэргэжлийн бүлэг	10	Д.Батцэнгэл
32		Ариутгал халдваргүйжүүлэлийн бүлэг	4	
33	Мэдээлэл холбооны сүлжээ ТӨҮГ – ын Ховд аймаг дахь газар	Харилцаа холбоо, зарлан мэдээллийн бүлэг	8	С.Лхагвасүрэн
34	Ховд Нисэх буудал	Нисэх буудлын аюулгүй байдлын бүлэг	8	Г.Жаргал
35	Аймгийн Улаан загалмайн хороо	Анхны тусламжийн нөхөрлөл	10	Б.Одонпүрэв
36	Аймгийн Ховд телевиз	Мэдээлэл, сурталчилгааны бүлэг	6	Ж.Самбалхүндэв
37		Ухуулга, сурталчилгааны бүлэг	6	
38	Онцгой байдлын газрын Эрэн хайх аврах анги	Аврах, гал унтраах бүлэг	14	Д.Очирбадам
39	Жаргалант сум	Сумын ерөнхий зориулалттай мэргэжлийн анги	66	Ц.Ганданповрон